

МОНГОЛ УЛС: АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН АНХДУГААР ТАЙЛАН 2012



Implemented by **giz** Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH



DDC
338.9
A-366

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН АНХДУГААР ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2013

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Сэнтрал Тауэр 1010а,
Сүхбаатарын талбай,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот,
Монгол Улс

Утас: 976-11-321927
Факс: 976-11-321926

Цахим шуудан: info@ecrc.mn
Цахим хуудас: www.ecrc.mn
Фейсбүүк хуудас: <http://www.facebook.com/ecrcmn>
Твиттер хуудас: <https://twitter.com/ursulduhchadvar>

ISBN 978-99962-56-56-1

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Бүтээлийг зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, ямар нэг хадгалах системд оруулахыг хориглоно.



ИРГЭН ТӨВТЭЙ БОДЛОГО
БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ХӨГЖИЛ
ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ МОНГОЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч
Цахиагийн ЭЛБЭГДОРЖ

ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн өнөөгийн түвшнийг бодитойгоор тольдсон анхны судалгааны үр дүн болох Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан хэвлэгдэн гарч байгаа баяртай байна.

Манай эдийн засаг огцом өсөж байгаа ч нийгэм “Уул уурхайн Монгол”, “Хотын Монгол”, “Хөдөөгийн Монгол” гэж гурав хуваагдаж байгааг Дэлхийн өрсөлдөх чадварын төвийг үүсгэн байгуулагч, профессор Стефан Гарелли тэмдэглэж байв. Үнэхээр ч нийслэл хот маань өсөлт, хөгжлийн бужигнаанд дарагдаж, хүн ам, автомашинаа дийлэхгүй түгжирч байхад орон нутгийн иргэд эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүртэлгүй өнгөрөх аюул нүүрлэж байна. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа нэмэгдэхийн хэрээр багаас сүм, сумаас аймаг, аймгаас хотыг чиглэх нүүдэл тасрахгүй нь.

Хөдөө орон нутгийг хөгжүүлэх нь үе үеийн эрх баригчдын гол зорилтуудын нэг байсаар ирэв. Энэ дашрамд, УИХ-ын баталсан Төсвийн тухай шинэ хуулийг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Төвлөрлийг сааруулах, иргэдийн оролцоотой төсвийн менежментийг хэрэгжүүлэх, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх үзэл баримтлал уг хуулинд туссан нь хөдөөгийн хөгжилд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Гэвч орон нутгийг хөгжүүлэхийн тулд аймгуудын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, тэдгээрийн давуу ба сул талуудыг тодорхойлох нь туйлын чухал. Өмнө нь бид орон нутгийн хөгжлийн тухай ярихдаа нэг хүнд ногдох ДНБ, ажилгүйдэл, ядуурал зэрэг үзүүлэлтийг л ашигладаг байлаа. Харин энэхүү судалгаа нь Монголын 21 аймгийн өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлохын тулд 180 шалгуур үзүүлэлтийг ашигласан юм. Нийгэм, эдийн засгийн бүхий л голлох үзүүлэлтийг харьцуулаад зогсохгүй аймаг тус бүрт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн үнэлэлт, дүгнэлтийг тусгасан нь аймгуудын хөгжлийн өнөөгийн байдлыг хамгийн бодитойгоор харуулсан мэдээллийн санг бүрдүүлсэн гэж бодож байна.

Ийнхүү нэр их ажлыг нугалж, 21 аймгийн өрсөлдөх чадварыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу шинжилсэн Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн хамт олондоо гүн талархал илэрхийлье! Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан нь бодлого боловсруулагчдын хувьд найдвартай, шинэлэг, цогц мэдээлэл олж авах чухал эх үүсвэр болно гэдэгт итгэж байна. Энэхүү тайлан нь өнөөгийн бодит дүр зургийг илэрхийлж байгаа бөгөөд тайланг жил бүр шинэчилж чадвал аль аймаг хэрхэн урагшилж, эсвэл ухарсныг бодитоор хэмжих боломж бүрдэж, улмаар холбогдох бодлого, үйл ажиллагаа явуулах “багаж ном” болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Пунцагийн Цагаан

Удирдах Зөвлөлийн Тэргүүн

СУДАЛГААНЫ БАГ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Удирдах Зөвлөлийн тэргүүн П.Цагаан

Захирал Б.Лакшми

Менежер И.Одончимэг

Судалгааны багийн ахлагч Э.Тунгалаг

Судлаач, эдийн засагч Р.Лхагвасүрэн

Судалгааны туслах ажилтан Х.Есөнчулуу

Олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Мөнхчимэг

www.ecrc.mn



ЭЗБӨЧСТ-ийн хамт олон

Зүүн гар талаас:

И.Одончимэг, Э.Тунгалаг, Д.Мөнхчимэг, Б.Лакшми, Х.Есөнчулуу

2013 оны 1 дүгээр сар

ТАЛАРХАЛ



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ) маань үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлэн тэлсээр байгааг дуулгахад таатай байна.

Бид 2010 оноос эхлэн Дэлхийн өрсөлдөх чадварын төвтэй хамтран Монгол Улсын өрсөлдөх чадварын тайланг жил бүр боловсруулан гаргадаг болсон нь шийдвэр гаргагчдын хувьд мэдээллийн найдвартай эх үүсвэр болж чадлаа. Харин одоо бид 21 аймгийн өрсөлдөх чадварыг дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу шинжилснээ ийнхүү Танд хүргэж байна.

Энэхүү санаачилгыг дэмжиж, Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг гаргахад үнэтэй хөрөнгө оруулалт хийсэн ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр болон аймгуудын бизнес эрхлэгчдийн санал бодлыг судлахад тусалсан Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, түүний орон нутаг дахь салбар танхимууд, тэдгээрийн хамт олон болон судалгаанд оролцогчдод гүнээ талархаж байна. Түүнчлэн бидэнтэй хамтран ажиллаж ирсэн түншүүддээ талархал илэрхийлэх нь зүйтэй. Дэлхийн өрсөлдөх чадварын төв, Үндэсний хөгжлийн хүрээлэнг энд онцгойлон дурдъя.

Аймгуудын нийгэм, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн санал, хүлээлтийг харуулсан уг тайлан бодлого боловсруулагчид, судлаачид төдийгүй Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт ажил хэрэгч хүмүүст хэрэгцээтэй байна хэмээн найдаж байна.

Энэхүү тайланг сонгон авсан Танд ЭЗБӨЧСТ-ийн хамт олныхоо өмнөөс ажлын өндөр амжилт хүсэж, оюуны мэлмий тань тунгалаг байхыг ерөөе.

Боожоогийн Лакшми

Ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгч

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД



Real World. Real Learning®

Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэн
Дэлхийн өрсөлдөх чадварын төв



ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр



Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим



Үндэсний хөгжлийн хүрээлэн



Монголын эдийн засгийн форум

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ



Үндэсний статистикийн хороо



Монголбанк

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм Таны энэ өдрийн амрыг айлтгая!

Монгол Улс шилжилтийн үеэ даван туулж, өсөлт хөгжлийн гараагаа нэгэнт эхэлсэн боловч бүс нутгуудын хэмжээнд хөгжлийн нөхцөл хангалттай бүрдэж амжаагүй байна. Дэд бүтэц сул хөгжсөн, санхүүгийн үйлчилгээ хүртээмжтэй бүс зэрэг шалтгааны улмаас хөдөө орон нутгийн хөгжил сул, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадвар дорой, хүн амын амьжиргааны түвшин доогуур байгаа юм. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв энэхүү чухал асуудлыг хөндөн, Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг анх удаа боловсруулан гаргаж байгаад баяртай байна.

ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр нь Дархан-Уул, Орхон, Завхан аймагт орон нутгийн нөөц бололцоог тогтвортой ашиглах замаар тухайн бүс нутгийн эдийн засгийг эрчимжүүлэх нөхцөл бололцоог сайжруулах зорилготойгоор 2006 оноос хэрэгжиж байна. Тус хөтөлбөрийн зүгээс Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг боловсруулж хэвлэх ажилд санхүүгийн туслалцаа үзүүлсэн нь орон нутгийн хөгжилд дорвитой нэмэр болно гэдэгт итгэж байгаа билээ.

Монгол Улсын 21 аймгийн өрсөлдөх чадварыг өргөн цар хүрээтэй судалгаанд үндэслэн тодорхойлсон энэхүү тайлан нь бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх бодлого, арга зүйг сайжруулах үүрэг бүхий бодлого боловсруулагчдын ажилд үнэтэй тус хүргэнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Санжжавын Байгалмаа

*ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн
Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн
Үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан захирал,
Санхүүгийн үйлчилгээг сайжруулах хэсгийн ахлагч*



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн тухай

Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулах хамгийн дөт бөгөөд үр дүнтэй арга замыг судалгааны дагуу тодорхойлж, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах зорилго бүхий Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ) 2010 онд үүсэн байгуулагдсанаасаа хойш үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлсээр байна. Бид эх орныхоо эдийн засаг, өрсөлдөх чадварыг олон улсын аргачлалын дагуу хэмжиж, энэ чиглэлээр найдвартай, өргөн цар хүрээ бүхий мэдээллийн санг бий болгохоор ажиллаж буй.

ЭЗБӨЧСТ нь Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэн (ОУУХХ)-гийн Дэлхийн өрсөлдөх чадварын төв (ДӨЧТ)-тэй хамтран Монгол Улсын өрсөлдөх чадварын тайланг гурав дахь жилдээ бэлтгэн боловсруулж байгаа бол Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг ийнхүү анх удаа гаргаж байна. Үүний зэрэгцээ бид макро эдийн засгийн сар тутмын тойм, Банкны салбарын өрсөлдөөний тойм зэрэг “мэдлэгийн бүтээгдэхүүн” тогтмол гаргадаг билээ.

Түүнчлэн ЭЗБӨЧСТ нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, өрсөлдөх чадварын тухай үнэн зөв мэдлэг, мэдээллийг дотооддоо төдийгүй олон улсад хүргэхийг эрмэлзэж буй. Энэ чиглэлээр найдвартай эх үүсвэр болгон ашиглаж болох судалгааны тайлан, илтгэлүүдийг боловсруулан гаргахын зэрэгцээ улс орны өрсөлдөх чадварын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор сургалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулдаг билээ. Тухайлбал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, АНУ-ын ОУХА-ийн Бизнесийг дэмжих санаачилга төсөл, Азийн хөгжлийн банк, Монголын бизнесийн зөвлөл болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран “Өрсөлдөх чадвар, бизнесийн орчныг сайжруулах замын зураглал” боловсруулан Шинэчлэлийн Засгийн газарт өргөн барьсан.

Бид Монголын эдийн засгийн форумыг үүсэн байгуулагдсан цагаас нь хамтран зохион байгуулж ирсэн бөгөөд эдүгээ Засгийн газрын “Шинэчилж шийдье-222” уулзалтыг дэмжин ажиллаж байна.

ГАРЧИГ

Товчилсон нэрсийн жагсаалт	13
ХӨГЖЛӨӨС ГЭЭГДСЭН ХӨДӨӨГИЙНХНИЙ ХҮЛЭЭЛТ	14
СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ.....	19
АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ.....	25
Өрсөлдөх чадварын хүчин зүйлс	26
Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 2012.....	27
Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ	33
АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	37
СТАТИСТИК ХҮСНЭГТҮҮД.....	81
1 Эдийн засгийн тамир тэнхээ.....	83
2 Засаглалын үр ашиг.....	95
3 Бизнесийн үр ашиг	105
4 Дэд бүтэц.....	115
ХАВСРАЛТ	139
Өрсөлдөх чадвар судлалын тухай ерөнхий ойлголт.....	140
Мэдээллийн эх сурвалж, тайлбар	142

Аймгуудын өрсөлдөх чадварын төлөв байдал

АРХАНГАЙ.....	38
БАЯН-ӨЛГИЙ.....	40
БАЯНХОНГОР.....	42
БУЛГАН.....	44
ГОВЬ-АЛТАЙ.....	46
ГОВЬСҮМБЭР.....	48
ДАРХАН-УУЛ.....	50
ДОРНОГОВЬ.....	52
ДОРНОД.....	54
ДҮНДГОВЬ.....	56
ЗАВХАН.....	58
ОРХОН.....	60
ӨВӨРХАНГАЙ.....	62
ӨМНӨГОВЬ.....	64
СҮХБААТАР.....	66
СЭЛЭНГЭ.....	68
ТӨВ.....	70
УВС.....	72
ХОВД.....	74
ХӨВСГӨЛ.....	76
ХЭНТИЙ.....	78

Товчилсон нэрсийн жагсаалт

АХБ	Азийн хөгжлийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДӨЧТ	Дэлхийн өрсөлдөх чадварын төв
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
МБ	Монголбанк
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

ХӨГЖЛӨӨС ГЭЭГДСЭН ХӨДӨӨГИЙНХНИЙ ХҮЛЭЭЛТ

Монгол Улс эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд толгой цохиж буй. 2011 онд ДНБ-ий өсөлт 17.5 хувьтай гарсан бол 2012 онд энэ үзүүлэлт бага зэрэг буурсан ч (12.3 хувь) хоёр оронтой тоог хадгалсан хэвээр байна. Гэвч эдийн засгийн энэхүү өсөлт хөгжлийн үр шимийг Монгол Улсын иргэд хангалттай мэдэрч, хүртэж чадаж байна уу? Энд тэндгүй сүндэрлэх өндөр шилэн барилгуудаас эхлээд замын түгжрэл хүртэл сайн, муу олон үр дагавар өөрчлөлтийг гэрчилнэ. Ямар ч байсан Улаанбаатарт эдийн засаг эрчимжиж байгааг нүдээр харж, гараар барьж болох ажээ. Харин хөдөөд хөгжлийн сураг үгүй, нам гүм.

Улсын нийт ДНБ-ий 65 хувийг Улаанбаатар хотод, 10 хувийг “Эрдэнэт” үйлдвэр орших Орхон аймагт, үлдсэн ердөө 25 хувийг бусад 20 аймагт бүрдүүлж буй. Нэг хүнд ногдох ДНБ аймгуудад Улаанбаатар хотынхоос бараг 3 дахин бага байна. Орон нутагт дэд бүтэц сул хөгжсөн, зах зээлийн багтаамж бага зэргээс шалтгаалан бизнесийн хөгжил дорой, ажлын байр цөөн байна. Үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн 70 орчим хувь нь зөвхөн нийслэл хотод төвлөрчээ.

Ядуурлын түвшин хөдөөд 33.3 хувь байгаа бол хотод 26.6 хувьтай байна. Өөрөөр хэлбэл, хотын 4 хүн тутмын 1 нь ядуу байхад хөдөөд 3 хүн тутмын 1 нь ядуу байгаа юм. Улаанбаатар хотод ажилгүйдлийн түвшин 2011 оны байдлаар 5.6 хувьтай байхад Төвийн бүсэд 6.8, Хангайн бүсэд 8.3, Баруун бүсэд 10.8, Зүүн бүсэд 11.1 хувьд хүрчээ.

Ийнхүү уул уурхайн салбарын өсөлттэй холбоотой эдийн засаг, нийгмийн хөгжилд гарч буй нааштай өөрчлөлтийн хажуугаар хот, хөдөөгийн ялгаа гэсэн хуучин мэт боловч шинэ үзэгдэл улам гаарч байна. Хот, хөдөөгийн ялгаатай байдал нь үндсэндээ дараах байдлаар илрэн гарч буй юм. Үүнд:

- Хөдөөд зам тээвэр, дулаан, цахилгаан эрчим хүч, ариун цэврийн байгууламж, цэвэр усны хангамж зэрэг дэд бүтцийн хөгжил сул;
- Хөдөөгийн иргэд нийгмийн болон төрийн төрөл бүрийн үйлчилгээг, тухайлбал эрүүл

мэнд, боловсрол, соёлын үйлчилгээг хангалттай бөгөөд чанартай хүртэж чаддаггүй, хэрэглээний сонголт хийх боломж нь хязгаарлагдмал;

- Эдийн засаг, зах зээлийн байдал тааруу, мэдээллийн хүртээмж хангалтгүй байдгаас бизнесийн орчин муу хөгжсөн, ажил олоход хэцүү;
- Хүн амын амьжиргааны түвшин сул, амьдралын чанар болоод хэв маяг нь хотын иргэдийнхээс ихээхэн ялгаатай

Төвөөс алслагдах тусам хот, хөдөөгийн ялгаа нэмэгдэж байгаагаас амьдралын илүү таатай орчныг эрсэн иргэдийн багаас сум, сумаас аймаг, аймгаас Улаанбаатар хотыг чиглэх нүүдэл тасрахаа байв. 2010 оны Хүн ам, орон сууцны улсын тооллогын дүнгээр Улаанбаатар хотын цэвэр шилжих хөдөлгөөн 40 мянгаас хол давжээ.

Нэг л мэдэхэд нийт хүн амын бараг хагас нь газар нутгийн ердөө 0.3 хувийг эзлэх нийслэл хотоо бараадаж, Улаанбаатар хотод оршин суугчдын тоо албан ёсны мэдээгээр 1.2 саяас давлаа. Нийслэл нь хүн ам, барилга байшин, тээврийн хэрэгслийн ачааллаа дийлэхгүй утаа, түгжрэл, цахилгааны хязгаарлалттай нүүр тулж байхад орон нутаг эзгүйрч байна. Энэ бүхэн эргээд л мөнөөх хот, хөдөөгийн ялгааг улам гүнзгийрүүлж байгаа юм.

Байдал улам даамжирваас аймгуудын хөгжлийн дорой байдал улс орны хөгжлийг хойш татах, нийслэл хотод ачаалал хэт нэмэгдсэнээс байгаль орчны тэнцвэр алдагдах, хүн амын амьдрах орчныг доройтуулж, ажилгүйдэл, ядуурал ихсэх, баян ядуугийн ялгааг улам гааруулах зэрэг одоо ч ажиглагдаж буй нийгэм, эдийн засгийн олон сөрөг үр дагаврыг дагуулсаар байх болно. Тиймээс уул уурхайн салбарыг даган эдийн засагт гарч буй боломжуудад тулгуурлан орон нутагт илүү анхаарал хандуулах, аймаг бүрийг хөгжлийн нөөц боломж, онцлог нь тохируулан хөгжүүлэх, бодлогоор дэмжин хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, тэгш бус байдлыг арилгах, хөгжлийг тэгш хүртээхэд анхаарах шаардлагатай.

Хөдөөгийн хөгжил нь нийгэм, эдийн засаг, засаглал, хүрээлэн буй орчин зэрэг олон бүлэг хүчин зүйлээс шалтгаалж байдаг. Тэдгээрийг сайжруулахын тулд аймгуудын хөгжлийн өнөөгийн түвшинг тогтоож, давуу ба сул талыг судалгааны үндэслэлтэй тодорхойлох нь зүйтэй. Ингэснээр аймаг бүрийн тулгамдаж буй бэрхшээлийг зохистой шийдвэрлэж, байгаа боломжийг ашиглан өрсөлдөх чадварыг нь сайжруулах нөхцөл бүрдэх юм.

Энэ ч шаардлагын үүднээс аймгуудын өрсөлдөх чадварыг сайжруулж, эдийн засаг, нийгмийн өсөлт, хөгжлийг Монгол Улсын иргэдэд адил тэгш хүртээхэд хувь нэмрээ оруулах үүднээс ЭЗБӨЧСТ Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг боловсруулан гаргаж байна. 21 аймгаа өрсөлдөх чадварын 180 үзүүлэлтээр шинжилсний үр дүнд тодорхойлсон, шийдвэрлэвэл зохих хамгийн нийтлэг таван асуудлыг дор сийрүүлэв.

1. Авто зам, дэд бүтцийг хөгжүүлэх

Монголын өргөн уудам газар нутаг, сийрэг суурьшил бүхий хүн ам, эрс тэс уур амьсгал зэрэг нь дэд бүтцийн хөгжил сул байх суурь шалтгаан. Манай орны нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ердөө 0.01 км урт авто зам, 0.001 км урт төмөр зам ногдож байгаа нь чамлахаар үзүүлэлт¹ юм.

Зам бол эдийн засгийн хөгжлийн гол судас. Улс орны хөгжил Улаанбаатар хотоос халихгүй байгаа нь ч үүнтэй холбоотой. 21 аймгийн төвийг нийслэл хоттой авто замаар холбоход л орон нутаг цус сэлбэж, хөгжлийн үр шимийг хүртэж чадна. Монгол Улс ДНБ-ийхээ 1.5-2.0 хувийг автозамын салбарт зарцуулж буй нь олон улсын түвшинтэй ойролцоо боловч жилд дунджаар 100 км хатуу хучилттай зам тавьж ирсэн нь харьцангуй бага гэж Азийн хөгжлийн банкнаас гаргасан тайланд² тэмдэглэжээ.

Өмнө нь төсвийн хөрөнгө мөнгө бага байсантай холбоотойгоор дэд бүтцэд их хэмжээний хөрөнгө оруулж чадалгүй ирсэн. Харин 2012 онд Засгийн газар олон улсын зах зээлд 1.5 тэрбум ам.долларын бонд амжилттай гаргаж, бенчмарк тогтоов (Шинэчлэлийн Засгийн газар нийт 5

тэрбум ам.доллар босгохоор төлөвлөсөн). Энэхүү хөрөнгөөр төмөр зам, авто зам, эрчим хүч зэрэг дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн билээ. Ирэх дөрвөн жилийн хугацаанд аймгуудын төвийг нийслэлтэй авто замаар холбоод зогсохгүй транзит тээврийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны зам барьж ашиглалтад оруулах тухай Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан байна. Гэвч эдгээр зорилгод хүрэхийн тулд хөрөнгө оруулалтын орчин, технологи, хүний нөөц зэрэг олон асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

Хөдөө бизнес эрхлэгчид зам баригдаж, ашиглалтад орохыг тэсэн ядан хүлээж буй нь санал асуулгын үр дүнгээс харагдсан. Замыг шуурхай бөгөөд чанартай барих нь хамгийн чухал бөгөөд энэ тал дээр орон нутгийн иргэдийн хараа хяналтыг оролцуулах хэрэгтэй. Мөн одоо байгаа болон шинээр баригдах авто замыг зохистой арчлан хамгаалах нь барихаасаа ч дутахааргүй чухал асуудал юм.

2. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих

Жижиг дунд үйлдвэрлэл нь ажлын байрыг ихээр нэмэгдүүлж, ядуурлыг бууруулж чаддаг учраас улс орнууд бодлоготойгоор дэмжиж, хөгжүүлдэг.

Монгол Улсын санхүүгийн салбарын 95 хувийг бүрдүүлж буй банкуудын зээлийн өндөр хүү бизнес эхлэх, өргөжихөд том саад болж буй. Удирдах ажилтны санал асуулгын үр дүнгээс үзэхэд орон нутагт бизнес эрхлэгчдийн хувьд зээлийн хүү, татварын хэмжээ том дарамт болдог аж. Арилжааны банкуудын зээлийн хүү сарын 1.0-2.5 хувьтай байна. Жилдээ 20 орчим хувийн хүү төлөөд үйл ажиллагаа явуулна гэдэг ялангуяа хөдөөд бизнес эрхлэгчдийн хувьд үнэхээр бэрх даваа. Тиймээс ч хөнгөлөлттэй зээл авах хүлээлт орон нутагт их байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар улсын төсвөөс 2009 болон 2010 онд тус бүр 30 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бол 2011 онд Засгийн газар 280 тэрбум төгрөгийн бонд гарган зээлийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байдаг. Шинэчлэлийн Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөртөө зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулна гэсэн нь горьдлого төрүүлж буй. Гэвч энэхүү зорилгод хүрэхийн тулд төсөв, сангийн уялдаатай, ухаалаг бодлого баримталж, инфляцийг нам

1 Авто замын сүлжээний нягтралаар Монгол Улс харьцуулж буй 15 орноос 15 дугаар байрт, төмөр замын сүлжээний нягтралаар 14 дүгээр байрт жагсаж байна. "Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан", ЭЗБӨЧСТ, 2011

2 "Монгол Улс: Авто замын салбарын хөгжил-2016", АХБ, 2012

түвшинд байлгаж, улмаар зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Үүний зэрэгцээ татварын 2 дахь шатны шинэчлэл хийнэ гэж байгаа нь бизнес эрхлэгчдийн дунд хүлээлт үүсгэжээ. Монгол Улсад 2011 оны эцсийн байдлаар 48 мянга гаруй аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн 80 гаруй хувийг 1-9 ажилтантай жижиг, дунд аж ахуйн нэгж эзэлж байгаа ба 30 хувь нь л татвар тогтмол төлдөг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 гаруй хувийг ердөө 350 томоохон компани бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл, жижиг, дунд үйлдвэрүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх (1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийн ААНОАТ-ын 90 хувийг буцаан олгох) нь төсөвт төдийлөн муугаар нөлөөлөхгүй бөгөөд ажлын байрыг хамгийн олноор бий болгодог бизнес эрхлэгчдийн татварын дарамтыг хөнгөлж чадах юм.

3. Авлига, хүнд суртлыг халах

Транспаренси Интернэйшнл байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын индексийн судалгаагаар³ Монгол Улс 2012 онд 26 байраар урагшилж, 174 орноос 94 дүгээрт жагссан нь сайн мэдээ. Төрийн хүнд суртал, түүнээс үүдэж буй авлига, хээл хахууль нь Монголын нийгмийн хөгжлийг хойш чангаасаар ирсэн. Ялангуяа Баянхонгор, Архангай, Хөвсгөлчүүд хүнд сурталтай хамгийн ихээр нүүр тулдгийг санал асуулгын үр дүн харуулж байгаа юм. Сүүлийн жилүүдэд уул уурхайн хөгжлийг даган хөрөнгийн их хэмжээний урсгал орж ирж байгаа нь ил тод, шударга байдлыг улам ихээр шаардах болов.

Монголтой адил социалист байсан ихэнх орон нүсэр төрийн аппарат, оновчтой бус бүтэц, түүнээс үүдэх үүрэг хариуцлагын тодорхой бус байдал, хүнд суртал, авлига зэрэг асуудалтай адилхан нүүр тулж ирсэн. Энэ бүх асуудлыг маш богино хугацаанд шийдвэрлэж чадсан Гүрж улсын туршлагаас манай эрх баригчид судалж буй. Гэвч энэ нь шийдэмгий байдал, зоригтой шинэчлэлүүдийг шаардах нүсэр ажил юм.

Орон нутгийн хувьд юуны түрүүнд төрийн байгууллагуудын удирдлагын хэт улстөржсөн үзэл суртлыг халах хэрэгтэй. Мөн төсвийн зарцуулалт, тендерийн үйл ажиллагаа тунгалаг бөгөөд шударга байх ёстойг бүх аймгийн бизнес эрхлэгчид дуу нэгтэйгээр зарлаж байна.

3 "Corruption Perception Index", Transparency International, 2012

Аймгийн эрх баригчидтай "ойрхон" компаниуд л тендерт шалгарах, хөнгөлөлттэй зээл авах мэтээр төрийн дэмжлэгийг хүртдэг нь нууц биш болсон. Олон жилийн хугацаанд ужгирсан энэ байдлыг устгах нь зүйтэй.

4. Эрүүл мэнд, боловсролын тогтолцоог сайжруулах

"Эрүүл биед саруул ухаан оршино" хэмээн монголчууд ярьдаг. Эрүүл мэндийн үйлчилгээ хотод төвлөрч, хөдөөд мэргэжилтэн, тоног төхөөрөмж ихээхэн дутагдалтай, хоцрогдмол хэвээр байна. Хамгийн энгийн жишээ гэвэл Улаанбаатар хотод нэг их эмчид 240 хүн ногдож байгаа бол аймгуудад дунджаар 496 буюу нэг их эмчид 2 дахин олон хүн ногдож байна. Хөвсгөлийн нэг их эмчид 668 иргэн, Өмнөговийн нэг сувилагчид 450 иргэн ногдож байх жишээтэй. Боловсролын салбарын хувьд ч адил дүр зураг ажиглагдаж буй. Аймгуудад хичээлийн байр шаардлага хангахгүй, боловсон хүчин хүрэлцэхгүй байхын зэрэгцээ багш нарын үр чадвар хомс мэтийн мянган зовлон, түмэн бэрхшээл тулгарч байна.

Иргэд маань эрүүл, боловсролтой байж гэмээнэ Монгол Улс хөгжил цэцэглэлд хүрч чадна. Тиймээс ч эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг төр хариуцаж буй. Гэвч төр сайн менежер байж чаддаггүйгээ бататгаж буйн илрэл нь хөдөөд эмч, багш нарын хүрэлцээ хомс, үр чадвар нь сул байгаад зогсохгүй хүнд суртал, улстөржсөн үзэл хүртэл гаргах нь элбэг аж. Тиймээс эрүүл мэнд, боловсролын тогтолцоог зохистой байдлаар шинэчилж, эмч, багш нарын үр чадвар болоод харилцааны соёлыг дээшлүүлэх шаардлагатай болжээ. Нөгөө талаасаа иргэдийн хамгийн чухал хэрэгцээг хангаж байдаг эдгээр хүмүүсийг үр чадварыг нь харгалзан томилдог, эргээд түүнд нь тохирсон цалин урамшууллыг олгодог тогтолцоог бий болгох хэрэгтэй.

5. Уул уурхайн орлогыг зохистой ашиглах

Уул уурхайд хөтлөгдсөн эдийн засгийн огцом өсөлт хөдөө орон нутагт ч хөгжлийг авчирна гэсэн хүлээлт бий болов. Олон жилийн турш Монгол Улсын төсөв, эдийн засгийг тэтгэсээр ирсэн "Эрдэнэт" үйлдвэр байдаг учраас Орхон аймаг өрсөлдөх чадварын хувьд бусдаасаа хавьгүй илүү байгаа нь ойлгомжтой. Түүний араас орж буй Өмнөговь аймгийн амжилт ч Оюутолгойн бүтээн байгуулалттай холбоотой нь маргаангүй. Энэ үүрхэй 2013 оны эхний хагасаас бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж


эхлэхээр Монгол Улсын нийт эдийн засагт сайнаар нөлөөлнө. Тиймээс ашигт малтмалын салбараас орж ирж буй орлогоо зүй зохистой удирдаж, урт хугацааны хөгжил цэцэглэлийн үрийг аймаг бүрт суулгах нь зүйтэй.

Нөгөө талаас уул уурхайн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр түүний талаарх нийгмийн ойлголт муудаж байна. Нийгмийн зүгээс маш их дарамт, шахалт ирж байгаагаас бодлого боловсруулагчид хөрөнгө оруулагчдыг үргээх шийдвэрүүд гаргах боллоо. Ашигт малтмалын салбараа түшиглэн хөгжсөн Австрали, Канад зэрэг орон уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд ихэд анхаарсан байдаг. Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, байгаль хамгаалал, нөхөн сэргээлтэд анхаарч, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах нь чухал. Ингэснээр Монгол Улсад өнөөдөр бий болсон уул уурхайн салбар, нийгэм дэх үл ойлголцол буурч, улмаар тогтвортой хөгжлийн суурь болох юм.

Эцэст нь

Амьдрал бол сонголт. Ямар мэргэжил сонгох вэ, аль сургуульд сурах вэ, төгсөөд хаана ажиллах вэ, хэзээ гэр бүл зохиох вэ, хүүхдээ хаана сургах вэ? мэтийн сонголтуудын дунд бидний амьдрал өрнөсөөр. Эдийн засаг, нийгмийн хөгжлийг иргэн бүрт ижил хэмжээгээр хүртээнэ гэж байхгүй ч тэрхүү хөгжлөөс хүртэх боломжийг шүүрч авах сонголтуудыг хүн бүрт нээж өгөх нь чухал юм. Өнөөдөр хөдөө орон нутгийн иргэд амьдрал, амьжиргаагаа сайжруулах боломж олох нь байтугай эрүүл мэнд, боловсролын үйлчилгээгээ ч зохих ёсоор авч чадахгүй байна. Тиймээс ч хот бараадахыг илүүд үзэж буй хэрэг. Хөдөө ажиллаж, амьдрах нь тодорхой боломжуудыг нээж өгдөг давуу талтай болж байж л Улаанбаатарыг чиглэх их нүүдэл саарах билээ.

Хөдөө орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулахын тулд дээр дурдсан 5 асуудлыг шийдвэрлэхийн хажуугаар аймаг бүрт чиглэсэн хөгжлийн бодлого боловсруулах нь зүйтэй. Учир нь Монгол Улсыг бүрдүүлж буй 21 аймагт өөр өөрийн гэсэн онцлог, давуу ба сул талууд бий. Аймаг бүрийн давуу талыг ашиглан өрсөлдөх чадварыг нь дээшлүүлж, өөр хаана ч байхгүй боломжуудыг нээхэд Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан нэмэр болно хэмээн найдаж байна.



СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ

Судалгааны зорилго, ач холбогдол

Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны зорилго нь Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн өнөөгийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгуудын өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлоход оршино. Судалгаагаар аймаг бүрийн хөгжлийн давуу ба сул талыг тогтоож, өрсөлдөх чадварын боломж, чадавхийг үнэлэн тогтвортой, урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахад ашиглахуйц өргөн хүрээний мэдээллийн сан бүрдүүлнэ.

Бид өнөөг хүртэл Монгол Улсын аймгуудын өрсөлдөх чадвар, хөгжлийн түвшингийн талаар ярихдаа зөвхөн нэг хүнд ногдох ДНБ, ажилгүйдлийн түвшин гэх мэт эдийн засгийн ерөнхий статистик үзүүлэлтийг л ашигладаг байсан. Эдгээр ерөнхий үзүүлэлт нь эдийн засгийн бодит байдлыг тэр бүр илэрхийлж чаддаггүй. Харин уг судалгаа нь аймгуудын өрсөлдөх чадварыг илүү өргөн хүрээнд буюу эдийн засаг, засаглал, бизнес, дэд бүтцийн нийт 180 үзүүлэлтээр хэмжин, нэгдсэн байдлаар тодорхойлж байгаагаараа онцлог юм. Аймгуудын өрсөлдөх чадварын индекс нь цаашид орон нутгийн өрсөлдөх чадварын ахиц, өөрчлөлтийг хянах боломж олгоно. Учир нь аймгуудын хөгжлийг үнэлэх энэхүү судалгаа нь тодорхой аргачлалын дагуу тогтмол буюу жил бүр боловсруулагдан гарах билээ.

Аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулж, өрсөлдөх чадварын чиг хандлагыг тодорхойлохоос гадна тухайн аймгийн өрсөлдөх чадварыг хойш татаж буй эсвэл дээшлүүлж буй үзүүлэлтүүдийг тогтоож, өрсөлдөх чадварын давуу, сул талыг үнэлэх боломж олгож буй нь энэхүү судалгааны давуу тал юм. Ингэснээр ямар аймаг яагаад өрсөлдөх чадварын хувьд бусдаас сайн, эсвэл сул байгааг ойлгож мэдэх, тухайн аймаг давуу талаа хэрхэн ашиглаж болох, хөгжлийг хойш татаж буй сул талаа хэрхэн шийдвэрлэх шийдлийг олоход чухал эх үүсвэр болох юм.

Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан нь бодлого боловсруулагчдын хувьд аймгуудын өнөөгийн хөгжлийн түвшин, нөхцөл байдлыг бодитоор харж, орон нутгийг хөгжүүлэхэд чиглэсэн илүү үр ашиг бүхий шийдвэр гаргахад тус болохуйц мэдээллийн эх үүсвэр, гарын авлага байх юм. Түүнчлэн аймгийн удирдлагууд өөрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, бусад аймагтай харьцуулах, туршлага судлах боломжтой болж буй. Мөн ажил хэрэгч хүмүүс бизнесийн болон хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргахдаа орон нутгийн талаарх найдвартай бөгөөд цогц мэдээллийг энэхүү тайлангаас авч болох билээ.

Судалгааны онцлог

ЭЗБӨЧСТ санаачлан, аймгуудын өрсөлдөх чадварыг Монголд анх удаа цогцоор нь судалж байгаа учраас Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан онцлог юм. Энэ нь хот хөдөөгийн ялгаа, тэгш бус байдлыг арилгах асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, бодлого боловсруулагчдыг судалгааны бодитой мэдээллээр хангах, улмаар аймгуудын өрсөлдөх чадварыг сайжруулахад хувь нэмрээ оруулах бидний ажлын эхлэл юм.

Өрсөлдөх чадварын талаарх ойлголт нь харьцангуй шинэлэг бөгөөд бусдаас давуу байдлыг судлахаас илүүтэй тухайн улс, аймаг өөрийн нөөц боломжоо хэрхэн үр дүнтэй ашиглаж, өөрийн гэсэн өрсөлдөх чадварыг бий

болгож, амьдрах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж чадсан эсэхийг судалдаг. Тиймээс ч бид аливаа аймаг өөрийн өрсөлдөх чадварыг дэмжин хадгалах таатай орчныг бүрдүүлж чадсан эсэх, түүнийгээ тордон сайжруулж буй байдлыг дүгнэж, бусад аймагтай харьцуулан эрэмбэлсэн. Өөрөөр хэлбэл, тухайн аймаг өөрийн нөөц, боломж, онцлог давуу талаа зохистой удирдаж, аж ахуйн нэгжүүдээ бүтээмж өндөртэй ажиллах, ард иргэдээ чинээлэг хангалуун амьдрах боломжоор хангаж чадаж байна уу? гэдэгт энэхүү тайлан хариулт өгч байна.

Дашрамд дурдахад, уг судалгаа нь аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулан